



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 16 өдөр

Дугаар A/136

Эрдэнэт

┌ Үр дүнгийн мөнгөн урамшил олгох тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ын 2-ын “а”, Засаг даргатай байгуулсан контрактын үр дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 онд Засаг даргатай байгуулсан контрактын гэрээгээ “Сайн” үнэлгээтэй биелүүлсэн Хот тохижуулах газрын дарга Б.Оюунбаяр, “Маш сайн” үнэлгээтэй биелүүлсэн Нийтлэг үйлчилгээний албаны дарга Г.Пүрэвдээ нарт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосугай.

2.Хот тохижуулах газрын дарга Б.Оюунбаярт 950000 /Есөн зуун тавин мянган/ төгрөг, Нийтлэг үйлчилгээний албаны дарга Г.Пүрэвдээд 711230 /Долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун гучин/ төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг тухайн байгууллагын цалингийн сангаас гаргахыг дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ